



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/69/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залруулга аудитын явцад залрууллаа	18
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ӨЛЗИЙТ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.НАРАНГЭРЭЛ ТАНАА

2022.08.18 № 18
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,045,722.02	10,554,672.1
2	АВЛАГА	739,922.02	500,000
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	239,922.02	
4	Бусад авлага	500,000	500,000
5	Хувь хүмүүсээс авах авлага	500,000	500,000
6	БАРАА МАТЕРИАЛ	9,305,800	10,054,672.1
7	Хангамжийн материал	9,305,800	10,054,672.1
8	Бичиг хэргийн материал		491,310
9	Аж ахуйн материал	5,980,000	6,237,562.1
10	Сэлбэг хэрэгсэл	3,325,800	3,325,800
11	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,627,247,181.37	1,581,808,867.97
12	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,627,247,181.37	1,581,808,867.97
13	Биет хөрөнгө	1,615,472,181.37	1,570,108,867.97
14	Барилга, байгууламж, орон сууц	1,792,821,526.5	1,842,321,526.5
15	Хуримтлагдсан элэгдэл	-344,713,316.32	-415,880,563
16	Авто-тээврийн хэрэгсэл	216,537,604	216,537,604
17	Хуримтлагдсан элэгдэл	-161,256,187.58	-172,009,354.26
18	Машин тоног төхөөрөмж(компьютер)	73,030,011.4	80,420,611.4
19	Хуримтлагдсан элэгдэл	-28,067,300.28	-36,371,783.5
20	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,871,835	59,871,835
21	Хуримтлагдсан элэгдэл	-55,818,291.51	-60,296,391.91
22	Бусад үндсэн хөрөнгө	158,193,544	164,693,544
23	Хуримтлагдсан элэгдэл	-95,127,243.84	-109,178,160.26
24	Биет бус хөрөнгө	11,775,000	11,700,000
25	Програм хангамж	750,000	750,000
26	Хуримтлагдсан элэгдэл	-75,000	-150,000
27	Бусад биет бус хөрөнгө	11,100,000	11,100,000
28	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,637,292,903.39	1,592,363,540.07
29	НИЙТ ӨР ТӨЛБӨР		46,513.03
30	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		46,513.03
31	Өглөг		46,513.03
32	Ажилчидтай холбогдсон өглөг		46,513.03
33	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,637,292,903.39	1,592,317,027.04
34	Засгийн газрын хувь оролцоо	1,637,292,903.39	1,592,317,027.04
35	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	430,807,876.17	430,807,876.17
36	Хуримтлагдсан үр дүн	484,495,604.25	439,519,727.9
37	Өмнөх үеийн үр дүн	474,617,591.09	484,495,604.25
38	Тайлант үеийн үр дүн	9,878,013.16	-44,975,876.35
39	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	721,989,422.97	721,989,422.97
40	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,637,292,903.39	1,592,363,540.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	505,761,884	489,498,189.08
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,159,456	59,810,290.08
3	Нийтлэг татварын бус орлого	114,159,456	59,810,290.08
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	114,159,456	862,000
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,019,800	862,000
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	113,139,656	
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		50,730,600
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		8,217,690.08
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,602,428	429,687,899
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,644,828	48,370,999
11	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		18,028,000
12	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,644,828	30,342,999
13	Орон нутгийн төсвөөс санхүүжих	381,957,600	381,316,900
14	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	381,957,600	381,316,900
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	480,366,346.07	534,474,065.43
16	УРСГАЛ ЗАРДАЛ	480,366,346.07	534,474,065.43
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,624,304.97	531,835,165.43
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,507,800	226,272,113.03
19	Үндсэн цалин	227,507,800	226,272,113.03
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,325,377.98	30,834,760.02
21	Тэтгэврийн даатгал	21,228,177.98	21,785,660.02
22	Тэтгэмжийн даатгал	2,662,500	2,262,300
23	ҮОМШӨ-ний даатгал	1,819,400	1,809,800
24	Ажилгүйдлийн даатгал	454,900	452,500
25	Эрүүл мэндийн даатгал	4,160,400	4,524,500
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,570,930	33,346,938
27	Гэрэл, цахилгаан	2,474,430	2,040,000
28	Түлш, халаалт	29,096,500	31,186,938
29	Цэвэр, бохир ус		120,000
30	Хангамж, бараа материалын зардал	39,880,268	33,553,431.98
31	Бичиг хэрэг	3,541,590.56	1,750,290
32	Тээвэр, шатахуун	20,654,446.44	19,292,001.9
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,000	2,065,000
34	Ном, хэвлэл	305,000	258,000
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,060,000	880,000
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,542,370	9,308,140.08
37	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,242,600	
38	Бараа материал акталсны зардал	1,614,261	
39	Нормативт зардал	60,000	
40	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000	
41	Эд хогшил, урсгал засварын зардал	8,398,900	11,766,000
42	Багаж, техник, хэрэгсэл	1,316,000	1,840,000
43	Тавилга	60,000	
44	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,022,900	100,000
45	Урсгал засвар		9,826,000
46	Томиллолт, зочны зардал	2,235,000	2,000,000
47	Дотоод албан томиллолт	2,235,000	2,000,000
48	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,613,041	18,847,859.1

Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

49	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,838,241	18,163,259.1
50	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	52,500
51	Тээврийн хэрэгслийн татвар	108,900	108,900
52	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000	27,000
53	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	386,300	486,200
54	Газрын төлбөр	2,600	10,000
55	Бараа үйлчилгээний бусад зардал	124,032,987.99	175,214,063.3
56	Бараа үйлчилгээний бусад зардал	13,513,209	66,235,149.9
57	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		150,000
58	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,519,778.99	108,828,913.4
59	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,742,041.1	2,638,900
60	Бусад урсгал шилжүүлэг	3,264,241	1,929,400
61	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,264,241	1,929,400
62	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,477,800.1	709,500
63	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,477,800.1	709,500
64	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	25,395,537.93	-44,975,876.35
65	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,517,524.77	
66	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	15,517,524.77	
67	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,878,013.16	-44,975,876.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,807,876.17	721,989,422.97	474,617,591.09	1,627,414,890.23
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,807,876.17	721,989,422.97	474,617,591.09	1,627,414,890.23
3	Тайлант үеийн үр дүн			9,878,013.16	9,878,013.16
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,807,876.17	721,989,422.97	484,495,604.25	1,637,292,903.39
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	430,807,876.17	721,989,422.97	484,495,604.25	1,637,292,903.39
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,807,876.17	721,989,422.97	484,495,604.25	1,637,292,903.39
7	Тайлант үеийн үр дүн			-44,975,876.35	-44,975,876.35
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	430,807,876.17	721,989,422.97	439,519,727.9	1,592,317,027.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	392,622,228	430,549,899
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,019,800	25,362,000
3	Нийтлэг татварын бус орлого	1,019,800	25,362,000
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,019,800	25,362,000
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,019,800	862,000
6	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		24,500,000
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,602,428	405,187,899
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,644,828	48,370,999
9	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		18,028,000
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,644,828	30,342,999
11	Орон нутгийн төсвөөс санхүүжих	381,957,600	356,816,900
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	381,957,600	356,816,900
13	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	369,712,228.1	417,889,899
14	УРСГАЛ ЗАРДАЛ	369,712,228.1	417,889,899
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,982,428	415,250,999
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,430,000	226,225,600
17	Үндсэн цалин	227,430,000	226,225,600
18	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,703,100	30,540,500
19	Тэтгэврийн даатгал	21,605,900	21,491,400
20	Тэтгэмжийн даатгал	2,274,300	2,262,300
21	ҮОМШӨ-ний даатгал	1,819,400	1,809,800
22	Ажилгүйдлийн даатгал	454,900	452,500
23	Эрүүл мэндийн даатгал	4,548,600	4,524,500
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,902,500	33,604,500
25	Гэрэл, цахилгаан	2,508,000	2,040,000
26	Түлш, халаалт	29,394,500	31,444,500
27	Цэвэр, бохир ус		120,000
28	Хангамж, бараа материалын зардал	32,419,622	22,734,800
29	Бичиг хэрэг	2,000,000	2,000,000
30	Тээвэр, шатахуун	17,809,622	16,154,800
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,000	2,040,000
32	Ном, хэвлэл	240,000	240,000
33	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,800,000	800,000
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,650,000	1,500,000
35	Эд хогшил, урсгал засварын зардал	8,718,900	11,940,000
36	Багаж, техник, хэрэгсэл	1,220,000	1,840,000
37	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,498,900	100,000
38	Урсгал засвар		10,000,000
39	Томилолт, зочны зардал	2,235,000	2,000,000
40	Дотоод албан томилолт	2,235,000	2,000,000
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,134,806	19,027,599
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,360,006	18,342,999
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	52,500
44	Тээврийн хэрэгслийн татвар	108,900	108,900
45	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000	27,000
46	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	386,300	486,200
47	Газрын төлбөр	2,600	10,000
48	Бараа үйлчилгээний бусад зардал	17,438,500	69,178,000
49	Бараа үйлчилгээний бусад зардал	17,438,500	69,028,000
50	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		150,000
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,729,800.1	2,638,900
52	Бусад урсгал шилжүүлэг	4,252,000	1,929,400

Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

53	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,252,000	1,929,400
54	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,477,800.1	709,500
55	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,477,800.1	709,500
56	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,909,999.9	12,660,000
57	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,910,000	12,660,000
58	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,910,000	12,660,000
59	Дотоод эх үүсвэрээр	22,910,000	12,660,000
60	Барилга байгууламж	14,330,000	
61	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,580,000	12,660,000
62	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-22,910,000	-12,660,000
63	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-0.1	0.00
64	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.1	0.00
65	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	381,816,900	381,469,400	347,500.00	99.91
2	УРСГАЛ ЗАРДАЛ	381,816,900	381,469,400	347,500.00	99.91
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,887,500	379,540,000	347,500.00	99.91
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,225,600	226,225,600	-	100.00
5	Үндсэн цалин	226,225,600	226,225,600	-	100.00
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,540,500	30,540,500	-	100.00
7	Тэтгэврийн даатгал	21,491,400	21,491,400	-	100.00
8	Тэтгэмжийн даатгал	2,262,300	2,262,300	-	100.00
9	ҮОМШӨ-ний даатгал	1,809,800	1,809,800	-	100.00
10	Ажилгүйдлийн даатгал	452,500	452,500	-	100.00
11	Эрүүл мэндийн даатгал	4,524,500	4,524,500	-	100.00
12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,604,500	33,604,500	-	100.00
13	Гэрэл, цахилгаан	2,040,000	2,040,000	-	100.00
14	Түлш, халаалт	31,444,500	31,444,500	-	100.00
15	Цэвэр, бохир ус	120,000	120,000	-	100.00
16	Хангамж, бараа материалын зардал	22,734,800	22,734,800	-	100.00
17	Бичиг хэрэг	2,000,000	2,000,000	-	100.00
18	Тээвэр, шатахуун	16,154,800	16,154,800	-	100.00
19	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,040,000	2,040,000	-	100.00
20	Ном, хэвлэл	240,000	240,000	-	100.00
21	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000	800,000	-	100.00
22	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000	1,500,000	-	100.00
23	Эд хогшил, урсгал засварын зардал	18,100,000	18,100,000	-	100.00
24	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000	8,000,000	-	100.00
25	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000	100,000	-	100.00
26	Урсгал засвар	10,000,000	10,000,000	-	100.00
27	Томилолт, зочны зардал	2,000,000	2,000,000	-	100.00
28	Дотоод албан томилолт	2,000,000	2,000,000	-	100.00

Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,100	684,600	347,500.00	66.33
30	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000	52,500	347,500.00	13.13
31	Тээврийн хэрэгслийн татвар	108,900	108,900	-	100.00
32	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000	27,000	-	100.00
33	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	486,200	486,200	-	100.00
34	Газрын төлбөр	10,000	10,000	-	100.00
35	Бараа үйлчилгээний бусад зардал	45,650,000	45,650,000	-	100.00
36	Бараа үйлчилгээний бусад зардал	45,500,000	45,500,000	-	100.00
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000	150,000	-	100.00
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,929,400	1,929,400	-	100.00
39	Бусад урсгал шилжүүлэг	1,929,400	1,929,400	-	100.00
40	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,929,400	1,929,400	-	100.00
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	381,816,900	381,469,400	347,500.00	99.91
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	
43	Улсын төсвөөс санхүүжих			-	
44	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	356,816,900	356,107,400	709,500.00	99.80
45	Орон нутгийн төсвөөс	356,816,900	356,107,400	709,500.00	99.80
46	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000	25,362,000	(362,000.00)	101.45
47	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000	862,000	(362,000.00)	172.40
48	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,500,000	24,500,000	-	100.00
50	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
51	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
52	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	-	100.00
53	Удирдах ажилтан	6	6	-	100.00
54	Гүйцэтгэх ажилтан	13	13	-	100.00
55	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.00
56	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	24	-	100.00
57	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	-	100.00
58	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14	14	-	100.00
59	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,370,999.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	48,370,999.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,370,999.00
4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,342,999.00
5	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,342,999.00
6	Бараа үйлчилгээний бусад зардал	30,028,000.00
7	Бараа үйлчилгээний бусад зардал	30,028,000.00
8	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,370,999.00
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,370,999.00
10	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,028,000.00
11	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,342,999.00
12	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	27,027,700.00
13	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлзийт сумын ЗДТГ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 2/34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах”, 67.1.2-д “Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах”, 67.1.3-д “Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Төрийн байгууллага болон төрийн албан хаагчдыг манлайлах ур чадвартай, иргэдэд шуурхай үйлчилдэг цомхон чадварлаг төрийн алба бүрдүүлж, хөгжлийн үзүүлэлтээрээ аймгийн зүүн бүсийн сумдын төв болох” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 381.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 44.9 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Авлага	0.74	0.50	(0.24)	(32.34)
Бараа материал	9.31	10.05	0.75	8.05
Үндсэн хөрөнгө	1,627.25	1,581.81	(45.44)	(2.79)
Нийт хөрөнгө	1,637.29	1,592.36	(44.93)	(2.74)
Өр төлбөр	-	0.05	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,637.29	1,592.32	(44.97)	(2.75)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,637.29	1,592.36	(44.93)	(2.74)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 32.3 хувиар буурсан байна.

Авлагын данс нь 0.74 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлага 0.24 сая төгрөгөөр буурч оны эцэст 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Бараа материалын үлдэгдэл 80. хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 9.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 112.4 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 8.2 сая төгрөг нийт 120.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 119.8 сая төгрөгийн зарцуулалт гарч, 10.05 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2.8 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,627.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 12.6 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 50.7 сая төгрөг нийт 63.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 108.8 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,581.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөрийн үлдэгдэл 0.05 сая төгрөг байна.

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлттэй холбоотойгоор 0.05 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 44.9 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	381.96	356.82	(25.14)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/	29.04	-	
Нэмэлт санхүүжилтийн орлого	9.64	48.37	38.73
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	50.73	50.73
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	8.22	8.22
урьд оны үлдэгдлээс санхүүжих	176.85	25.36	(151.49)
Үйл ажиллагааны орлого	597.49	489.50	(107.99)
Цалин, шимтгэлийн зардал	257.83	257.11	(0.73)
Бусад бараа үйлчилгээний зардал	223.76	274.73	50.97
Урсгал шилжүүлэг	43.62	2.64	(40.99)
Үйл ажиллагааны зардал	525.22	534.47	9.26
Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/	1.88		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	70.39	-44.98	(115.37)

Өлзийт сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 25.1 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан нь орон нутгийн орлогын гүйцэтгэл буурсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 410.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 72.9 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 337.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 13.2 хувиар буюу 381.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь ковид 19 цар тахал холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж болон давсан орлогын санхүүжилт 44.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 381.8 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 381.5 сая төгрөгийг зарцуулж, 0.03 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 0.01%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 48.3 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар ковид 19 цар тахлын тусгаарлах байрны хоол, хүнс, шатахуун, бусад зардалд зарцуулсан байна.

- Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод зориулж 0.9 сая төгрөг, ХХААГ-аас огтоно устгахад зориулж 6.9 сая төгрөг, Ар ус Ундарга ХХК-аас усны төлбөрт 9.7 сая төгрөг, ГБХЗГ-аас хамтарсан багийн бичиг хэрэг, шатахууны санхүүжилт 0.8 сая төгрөг, аймгийн Шуурхай штабаас ковид 19 цар тахлын хариу арга хэмжээний санхүүжилт 2.0 сая төгрөг нийт 20.3 сая төгрөгийн санхүүжилтийг сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой 18.0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын захирамжийн дагуу тусгаарлах байрны хоол, хүнс, аж ахуйн материал болон шатахууны зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд сумын Засаг даргын нөөц сангаас 14.7 сая төгрөгийн 14.4 тн тэжээлийн улаан буудай, 2250 ш боодол өвс тэжээлийг тус тус бэлтгэсэн байна.

Тус сумын Ямаат багт 2021 оны 2021 оны 12 дугаар сарын 16-наас гоц халдварт буюу шүлхий өвчин гарч 2788 толгой мал өвчилсөн байна.

Тайлант жилд сумын ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр П.Нарангэрэлийг 2021 оны 4 дүгээр сараас томилогдон ажиллаж байна.

Авилгатай тэмцэх газрын 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 05/4415 дугаар албан бичгээр П.Нарангэрэлийг энэ албан тушаалд томилох нь Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтыг зөрчихөөр байна гэсэн хариуг ирүүлжээ. Өлзийт сумын ЗДТГ-ын даргын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг аймгийн аймгийн Төрийн албаны зөвлөлөөс явуулсан ба нэр дэвшигч П.Нарангэрэлийг тухайн албан тушаалын шаардлагыг хангахгүй гэсэн үндэслэлээр шалгалтын бүртгэлээс хасч энэ сонгон шалгаруулалтанд тэнцсэн нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилуулахаар Өлзийт сумын Засаг даргад тогтоол гарган хүргүүлснийг сумын Засаг дарга томилохгүй татгалзжээ. Улмаар ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Нарангэрэл нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд гомдол гаргасан маргаантай асуудал аудитын явцад ажиглагдлаа.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 71 үндсэн зорилтын хүрээнд 156 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 381.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан аваагүй байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: УА3469 маркийн ХАНТЕР 2016 онд үйлдвэрлэгдсэн 29.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий 1 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 5.1 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 6.8 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлзийт сумын ЗДТГ нь 2021 онд нийт 438.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 407.0 сая төгрөгийн 129 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 31.4 сая төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 9.4 % буюу 11.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтыг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 228.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 213.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.

4.2 Албан шаардлага

- Санхүүгийн байдлын тайланд бүртгэлтэй 2001 оноос үүссэн 21 жилийн насжилттай 0.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй мөн тайлант жилд НДШ-ийн 0.046 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, авлага, өр төлбөрийг барагдуулах албан шаардлагыг хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Тус байгууллага нь 2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 245 нэр төрлийн 213.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал													
1	Өлзийт сумын ЗДТГ	Авлагын дансанд 2001 оноос үүссэн 21 жилийн насжилттай 0.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй мөн тайлант жилд НДШ-ийн 0.046 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	0.54					1	0.54			
2		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 245 нэр төрлийн 213.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй.	1	213.5							1	213.5	
3		2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй	1									1	
4		Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.	1	14.4	1	14.4							
Дүн			4	228.4	1	14.4			1	0.54	2	213.5	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал													
1	Өлзийт сумын ЗДТГ	МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 9.4 % буюу 11.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна	1	11.8					1	11.8			
2		31.4 сая төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	31.4							1	31.4	
Дүн			2	43.2					1	11.8	1	31.4	
Нийт дүн			6	271.6	1	14.4			2	12.3	3	244.9	